

ORDĀ

WEALTH TECH PLATFORM



976-7577-9444

invest@orda.mn



АГУУЛГА

1. ОРДА төслийн тухай
2. Хөрөнгө оруулалтын санал
3. Вискиний зах зээлийн ерөнхий мэдээлэл
4. Виски хөрөнгө оруулалтын хэрэгсэл болох нь
 - Ерөнхий мэдээлэл
 - Лонхоор нь худалдаж авах
 - Торхоор нь худалдаж авах
 - Вискиний санд хөрөнгө оруулах
 - Вискиний хөрөнгө оруулалтын жишээ
5. Вискиний үнэ цэнийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс
 - Ерөнхий хүчин зүйлс
 - Бусад хүчин зүйлс
6. Бидний сонгосон виски
 - Дэлгэрэнгүй мэдээлэл
 - Санхүүгийн төсөөлөл
7. Хөрөнгө оруулах үйл явц
 - Хэрхэн хөрөнгө оруулах вэ?
 - Хэрхэн буцааж хөрөнгө оруулалтаа татах вэ?
8. Үйл ажиллагааны ерөнхий дараалал
9. Хууль эрх зүйн орчин, эрсдэлийн удирдлага
 - Өмчлөл баталгаажуулалт
 - Даатгал
 - Кастодиан
10. Манай баг
11. Асуулт ба хариулт

ОРДА ТӨСЛИЙН ТУХАЙ

ОРДА та бүхэнд ирээдүйд үнэ цэнэ нь тогтмол өсөх, 2 төрлийн 2 торх сингл молт Шотланд вискиний хөрөнгө оруулалтыг санал болгож байна.

ОРДА бол хил хязгаараас үл хамааран бүхий л төрлийн хөрөнгийн (хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, ховор урлагийн бүтээл, цуглуулга зэрэг цаг хугацааны явцад үнэ цэнэ нь өсөх) өмчлөх эрхийг хэсэгчлэн арилжаалах боломжийг олгож, тухайн хөрөнгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, цаашлаад үнэ цэнийг өсгөх зорилготой платформ юм.

Манай платформ нь уламжлалт хөрөнгө оруулалтын практикт тулгардаг санхүүгийн хүндрэл буюу өндөр дүнгээр хөрөнгө оруулах шаардлага, гадаадын хууль эрх зүйн орчны мэдлэггүй болон хөрөнгө оруулалтын туршлагагүй байх зэрэг асуудлуудыг харилцагчийн өмнөөс шийдсэнээрээ онцлог.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНАЛ:

СОНГОЛТ 1:

Суурь хөрөнгийн төрөл	Торхтой виски(Refill Bourbon Hogshead≈250л)
Вискиний нэр	Glenrothes
Тоо хэмжээ	1 торх
Насжилт	7 жил
Алкохолын түвшин	66.42%
1 торхны нийт үнэлгээ*	£ 5,916.69 ≈ ¥23,669,320
1 торхоос гарах нийт лонх (0.7л)	314 шил
Нэгж эрхийн үнэ (1 шил)	£18.84 ≈ ¥75,380
Торхоо эргүүлэн худалдах хугацаа	5/1/2026 (12 нас хүрмэгц)
Хүлээгдэж буй өгөөж (Англи фунт стерирлингээрх ROI)	≈ 9.34% (дунджаар)**

*Худалдан авахтай холбоотой шимтгэлийн дараа

** Энэхүү өгөөжийн төсөөллийг бид өнгөрсөн хугацааны ижил төстэй үзүүлэлт бүхий вискиний борлуулсан үнийн түүхэн мэдээлэл дээр үндэслэн тооцоолсон болно. Вискиний үнэ нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хуулиар тогтдог тул энэхүү тогтоосон өгөөжийн хувь хэмжээ нь ирээдүйд өөрчлөгдөх магадлалтай.

СОНГОЛТ 2:

Суурь хөрөнгийн төрөл	Торхтой виски (Refill Bourbon Hogshead)
Вискиний нэр	BenRiach
Тоо хэмжээ	1 торх
Насжилт	9 жил
Алкохолын түвшин	59.10%
1 торхны нийт үнэлгээ*	£ 8,523.41 ≈ ¥34,095,000
1 торхоос гарах нийт лонх (0.7л)	250 шил
Нэгж эрхийн үнэ (1 шил)	£ 34.09 ≈ ¥ 136,380
Торхоо эргүүлэн худалдах хугацаа	5/1/2026 (14 нас хүрмэгц)
Хүлээгдэж буй өгөөж (Англи фунт стерилингээр ROI)	≈9.54% (дунджаар)**

*Худалдан авахтай холбоотой шимтгэлийн дараа

** Энэхүү өгөөжийн төсөөллийг бид өнгөрсөн хугацааны ижил төстэй үзүүлэлт бүхий вискиний борлуулсан үнийн түүхэн мэдээлэл дээр үндэслэн тооцоолсон болно. Вискиний үнэ нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хуулиар тогтдог тул энэхүү тогтоосон өгөөжийн хувь хэмжээ нь ирээдүйд өөрчлөгдөх магадлалтай.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Сүүлийн жилүүдэд олон улсад хөрөнгө оруулалтын салбар хүндхэн даваануудтай нүүр тулаад байгаа билээ. Зах зээлийн хэт өндөр хэлбэлзэл, уламжлалт хөрөнгө оруулалтын өгөөжийн хэлбэлзэл, дэлхийн мөнгөний бодлогын нөлөөгөөр зээлийн хүү бага байх зэрэг нь баялгийн менежментэд гэнэтийн бэрхшээл тулгарахад хүргэсэн. Нэмээд дэлхийн цар тахлын эдийн засагт үзүүлж байгааг нөлөөг мөн дурдахгүй өнгөрч болохгүй.


Sotheby's дуудлага худалдаагаар 60 жилийн настай 1 шил Macallan **1.5 сая фунт стерлингээр** зарагдаж рекорд тогтоосон ба тухайн жилийн 263 дугаартай торхноос савлаж борлуулснаар 2018 онд нэг ширхэг шотланд вискийг 1,2 сая фунт стерлингээр худалдаж авсан өмнөх дуудлага худалдааны рекордыг эвдсэн байна.

Хичнээн нөхцөл байдал муудсан ч нөгөө талд хөрөнгө оруулагчдад шинэ сонголт, шинэ хөрөнгө оруулалтын хэрэгслийг нээн илрүүлсээр байгаа билээ. Тухайлбал, саяхан гарсан торхтой вискиний зах зээлийн тойм мэдээнд дурьдсанчлан дэлхий даяар тодорхойгүй байдал үүссэн хэдий ч торхтой вискинд оруулсан хөрөнгө оруулалт тогтвортой өсөх хандлагатай байгааг мэдээлсэн байна. Энэ цуглуулга нь ихэвчлэн цөөн тоогоор гарсан торхнуудаас гаргаж авсан ба 10 жилийн хугацаанд цуглуулсан байжээ. Шотланд вискийг дэлхийн 180 гаруй улсын зах зээл рүү нийлүүлдэг ба 1 секунд тутамд 42 шил виски тээвэрлэгддэг гэсэн тооцоо бий.

Нэг цуглуулагчийн 467 шил бүхий цуглуулга 7.6 сая фунт стерлингээр зарагдсан нь урьдчилсан таамгаас ойролцоогоор хоёр дахин их байв. Их Британи Умард Ирландын Вант улсын хэмжээнд энэ жил гэхэд 20 сая торх виски нэрэгдэж дуусах бөгөөд энэ нь тус улсын нийт хоол хүнсний экспортын 21%-ийг эзэлж байгаа юм.

ВИСКИ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ:

Виски нь алт, мөнгө зэрэг үнэт металлууд, дарс, урлагийн бүтээл зэргийг үнэ цэнийн өсөлтөөрөө ардаа орхисон бөгөөд энэ нь вискийн нийлүүлэлт хязгаарлагдмал буюу их хэмжээгээр авах боломжгүй ба эрэлт, нийлүүлэлтийн энгийн хууль үйлчилж зах зээлийн ханшаар үнэ цэнэ нь тодорхойлогдож байдгаараа онцлог юм.



Хамгийн өндөр өгөөжтэй гэж хүлээн зөвшөөрөгддөг бусад төрлийн биет (алт) болон биет бус (S&P 500 index болон крипто валют) хөрөнгүүдтэй харьцуулахад виски нь үзүүлэлт сайтай болохыг та дээрх зургаас харж байна.



ВИСКИНИЙ ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Виски буюу 'whisky' нь Gaelic хэлний “uisge beatha”, “usquebaugh” буюу “амьдралын ус” гэсэн утгатай. Вискиний анхны үйлдвэрлэгчид нь Шотландын сүм, хийдүүд байлаа. Лам нар хамгийн энгийн нэрэгч тогоог ашиглан маш бага хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байв. Гэхдээ олонх нь вискиг эмийн журмаар хэрэглэдэг байлаа. Удалгүй вискиний технологи сүм, хийдийн хананаас хальж, фермерүүд виски үйлдвэрлэж эхэллээ. Цөөн хэдэн мал, үржил шимгүй газартай шотланд тариачид вискиний орцыг ихээр тариалах болжээ.

ШОТЛАНД ВИСКИ НЬ ДАРААХ ГУРВАН ҮНДСЭН ОРЦООС БҮРДЭНЭ:

- Буудай эсхүл эрдэнэ шиш
- Ус
- Исгэгч



ШОТЛАНД ВИСКИГ ДАРААХ ПРОЦЕССЫН ДАГУУ ХИЙДЭГ БАЙНА.




1. Тариаг соёолуулах

Тариаг талбайд усаар усан дэвтээж соёолуулж, цардуулыг элсэн чихэр болгох процессыг энэ үе шатанд хийх ба соёолсон тариаг дараа нь сайтар хатаана.



2. Бутлах

Соёолсон тариаг булгийн усыг халааж, нийлүүлэн бутлах ба энэ үед тус шингэн нь чихэрлэг болсон байна.




3. Исгэх

Бэлтгэсэн шингэн рүү исгэгч хийснээр исгэлтийн процесс эхлэх бөгөөд энэ үед тухайн шингэн нь дор хаяж 8% спиртийн агууламжтай болсон байна.




4. Хуримтлуулах ба дахин исгэх

Нарийн хүзүүтэй зэс тогоонд тус шингэнийг оруулан буцалгах бөгөөд ууршсан шингэн нарийн хоолойгоор гоожиж хуримтлагдах ба энэ үед спиртийн агууламж 20%-д хүрнэ. Тухайлбал Single Malt Whisky гаргахад энэ процессыг 2 удаа давтан хийнэ.



5. Торхонд "насжуулах"

Царс модоор хийсэн торхонд хийн, хамгийн багадаа 3 жил исгэж байж Шотланд виски гэж нэрлэх боломжтой болдог байна. Царс модон торх нь вискинд алтан шаргал өнгийг оруулдаг.




6. Савлах

Эцэст нэрж дууссан, хугацаа нь болсон вискиг лонхонд савалж борлуулахад бэлэн болгох ба энэ нь мөн нэмэлт төлбөртэй үйлчилгээ болно.

ТОРХНЫ ТУХАЙД:

Торх нь вискиний нэрэлтэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд түүний хэмжээ, насжилт, ашигласан байдал бүгд вискиний амтад шууд нөлөөлдөг. Торхны хэмжээний хувьд жижиг нь 80л байдаг бол хамгийн том нь 500л хэмжээтэй байдаг ба бүгд өөрийн гэсэн нэршилтэй байна.



СИНГЛ МОЛТ ВИСКИГ НЭРЭХЭД НИЙТЛЭГ АШИГЛАДАГ 2 ТӨРЛИЙН ТОРХЫГ ТОВЧ ТАНИЛЦУУЛБАЛ:

Barrel: 190–200 литрийн багтаамжтай тус торхыг цагаан царс модоор хийсэн ба голцуу Америк бурбон (bourbon) вискиг исгэсний дараа Шотланд виски нэрэхэд ашигладаг бөгөөд дахин ашиглагддаггүй онцлогтой.

Hogshead: 225–250 литрийн багтаамжтай, хамгийн түгээмэл ашиглагддаг ба barrel-тай ижил түүхтэй торх, олдоц нь элбэг ба том хэмжээ нь илүү урт хугацаагаар исгэх боломжийг олгодог.



ВИСКИНИЙ ЗАХ ЗЭЭЛ


Виски нь өрнөдөд төдийгүй дорнодод тансаг зэрэглэлийн алкохолд тооцогдох болоод байна. Дээд зэрэглэлийн, онцгой хувилбарын /special edition/ вискины эрэлт дэлхий даяар нэмэгдэж байгаа нь вискиг анхаарал татахуйц хөрөнгө оруулалтын хэрэгсэл болоход нөлөөлж байна.




"Global Whiskey Market" судалгаагаар нийт вискины зах зээл 2019 онд 61.7 тэрбум ам.доллар гэж тооцоолсон бол жилд дунджаар 6.5 хувь өсч, 2026 он гэхэд 95.9 тэрбум ам.доллар болж өснө гэж таамагласан байна.

Азид ховор вискиг олж эзэмших нь нэр төрийн илэрхийлэл гэж үзэж байгаа бол Европын иргэд вискиг хэд хэдэн зорилгоор худалдан авч байна. Жишээлбэл, тухайн вискины түүх болон амт чанарт татагдах, ховор зүйлсийн цуглуулгандаа нэмэх, эсхүл онцгой арга хэмжээнд хэрэглэх зорилгуудыг дурдаж болно.

Ховор вискины үнэ цэнэ ойрын ирээдүйд буурах шинж тэмдэг зах зээлд ажиглагдахгүй байна. Хэрэв "Rare Whisky Apex 1000 Index" буюу хамгийн эрэлттэй 1,000 ширхэг Шотланд вискины үнийн индексийг харвал 2010-2020 оны хугацаанд 5 орчим дахин өссөн болохыг харж болно.



Вискины эрэлт нэмэгдэж байгаа нэгэн гол шалтгаан нь хөрөнгө оруулагч нар вискиг өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл мөн гэж үзэж байгаатай шууд холбоотой билээ.



Вискинд хөрөнгө оруулалт хийх нийтлэг 2 арга зам байх бөгөөд хамгийн энгийн арга нь лонхтой виски худалдан авах юм.

Ингэхдээ шинэ эсхүл өндөр настай лонхолсон виски авч болох бөгөөд бренд эсхүл дистиллер компанийг чухалчлах хэрэгтэй. Гэвч зөв лонх вискиг дуудлага худалдаа болон шинээр худалдаанд гарахад нь олж, таньж мэдэх нь цаг хугацаа болон мэдлэг, туршлага ихээхэн шаарддаг.

Вискинд хөрөнгө оруулах өөр нэгэн арга зам бол торхтой виски худалдаж авах юм. Худалдан авах торхтой виски нь шинэхэн савалсан эсхүл аль хэдийн олон жил дарсан байж болно. Олон янзын торх бүхий виски худалдан авсанаар сайн хөрөнгө оруулалтын багц үүсгэж болох бөгөөд торх вискины насжилт ихсэх тусам үнэ цэнэ нь өсдөг.

Ховор лонхтой вискиг худалдан аваад 10 жилийн дараа зарахад өгөөж хүртэж болох хэдий ч торхтой вискиг харьцуулахад ихэвчлэн бага байдаг. Учир нь виски зөвхөн торхонд л исэж, исгэгдсэн хугацаагаар нас нь тоологддог. Иймээс лонхтой вискины үнэ зөвхөн зах зээлийн нөлөллөөс хамааралтай байх бол торхтой вискины үнэ зах зээлийн нөхцөл байдлаас гадна цаг хугацаа өнгөрөхийн хэрээр нэмэгдэж байдгаараа онцлог.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЖИШЭЭ



Хамгийн өндөр үнэд хүрсэн вискинүүдээс жишээ татвал 2019 оны 10 дугаар сард Макаллан дистиллерийн 1926 онд дарсан 60 настай 'Fine and Rare' шошготой виски Лондон дахь дуудлага худалдаанд 1.5 сая фунт стерлинг буюу 1.9 орчим сая ам.долларын үнээр худалдаалагдаж хамгийн үнэтэй лонх вискины рекордыг тогтоож байсан.



Өмнө дурдсан шиг өндөр үнэ бүхий биш ч сүүлийн үед анхаарал татаад буй бас нэгэн виски бол "Highland distillery Nc'nean" дистиллерийн анхны лонх виски болох "Ainnir" юм. Nc'nean нь Morvern-ын хойгт байрших бөгөөд 2013 онд үүсгэн байгуулагдаж байсан бөгөөд 2017 онд үйлдвэрлэлээ эхлүүлж анхны вискигээ ийнхүү 2020 онд задалсан байна.

Уг вискинээс зөвхөн 1,320 ширхэгийг үйлдвэрлэсэн бөгөөд хамгийн эхний лонх вискиг 41,004 фунт стерлинг буюу 54,183 ам.доллараар худалдсан байна.

ВИСКИНИЙ ҮНЭЛГЭЭНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

ВИСКИНИЙ ҮНЭД ДАРААХ ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛҮҮД НӨЛӨӨЛДӨГ. ҮҮНД:



Эдийн засгийн хүчин зүйлс:

- Үйлдвэрлэлийн өртөг
- Маркетингийн өртөг
- Хэрэглэгчийн эрэлт
- Бие даасан савалгаа
- Торхны төрөл ба үнэ
- Ложистик болон бусад зардлууд
- Архинд ногдуулсан онцгой албан татварууд
- Шударга бус өрсөлдөөн (Ихэнхдээ өрсөлдөгчийн зүгээс)

Бусад хүчин зүйлс:

- Гарал үүсэл
- Торхны төрөл
- Торхны ашигласан байдал (зарим тохиолдолд дарсанд ашигласан торхыг вискийг илүү төгс амттай болгодог тул энэ төрлийн торхонд нэрсэн виски үнэтэй байдаг)
- Виски нэрэх үйлдвэр
- Брэнд
- Single эсхүл холимог

Орц, нэрэлтгэй холбоотой:

- Усны чанар
- Ашиглагдах хүлэр (Шотланд вискиний хувьд)
- Газарзүйн байрлал
- Торхны чанар
- Насжилт
- Виски нэрэх хүний нөөцийн чадавхи

BenRiach

Өгөөжийн хүлээлтийн матриц (фунт стерлинг)

BenRiach	Year 1	Year 2	Year 3	Year 4	Year 5	ROI
Mixed	12%	13%	15%	17%	20%	50.08%
12%	12%	12%	12%	12%	12%	29.43%
13%	13%	13%	13%	13%	13%	35.32%
15%	15%	15%	15%	15%	15%	47.72%
17%	17%	17%	17%	17%	17%	61.02%
20%	20%	20%	20%	20%	20%	82.75%

ВИСКИНД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ДАРААЛАЛ:



Хөрөнгө оруулалтын танилцуулгыг мэйлээр хүлээн авч сайтар танилцана.



2 төрлийн вискиний сонголтоос сонгож, алийг хэр хэмжээгээр авахаа шийдэж, захиалга өгнө. Үүний тулд invest.orda.mn холбоосоор орж хөрөнгө оруулагчийн анкет болон захиалгын хуудас бөглөнө.



Хөрөнгө оруулалтын гэрээг хүлээн авч танилцан гарын үсэг зурж захиалгаа баталгаажуулна.
Хөрөнгө оруулалтын төлбөрийн нэхэмжлэх хүлээн авч холбогдох дансанд төлбөрийг шилжүүлнэ.



Хөрөнгө оруулалтын менежментийн компаний торхны гэрчилгээг хүлээж авна.



Гэрчилгээг Кастодиан банканд хадгалуулж, таны өмчлөлийг баталгаажуулах ба бид баталгаажуулсан даруйд танд мэдэгдэнэ.



Тэгээд... Хүлээнэ.

ВИСКИНИЙ ТОРХОНД ХӨРӨНГӨ ОРУУЛАХДАА ДАРААХ АСУУЛТУУДЫГ ТА ӨӨРӨӨСӨӨ АСУУГААРАЙ.

Хөрөнгө оруулах хэмжээгээ тодорхойл.

Бондтой харьцуулахад тодорхой, тогтмол өгөөж байхгүй ч гэлээ жил бүр үнэ цэнэ нь өсдөг тул та хүлээцтэйгээр торхонд байгаа вискигээ нэрэгдэж дуусахыг хүлээхүйц хэмжээний хөрөнгө оруулалтыг санал болгож байна.

Хугацаагаа тодорхойл

Таны авсан торх виски 5-7 жил торхондоо сайтар бүрэн боловсорсны дараа хамгийн төгс төгөлдөр, баялаг амтандаа хүрч, үнэ цэнэ нь тэр хэрээрээ нэмэгддэг тул та хамгийн багадаа 3 жил өгөөжийг нь хүлээж чадах эсэхээ мөн тунгаах хэрэгтэй.

Яагаад торх вискинд хөрөнгө оруулж байгаа шалтгаанаа тодорхойл.

Та цэвэр хөрөнгө оруулалтын зорилгоор хөрөнгө оруулж байна уу, эсхүл өөрийн таашаалдаа нийцсэн ховор цуглуулгатай болохоор худалдан авч байна уу, хэн нэгний төрсөн өдөр, хуримын ойд зориулж энэхүү торхны нэгж эрхийг, эсхүл баяр ёслолоор хэрэглэхээр худалдан авч байна уу.

ТА АВСАН ТОРХ ВИСКИНИЙ НЭГЖ ЭРХЭЭ ХУГАЦААНААСАА ӨМНӨ БУЦААЖ ХУДАЛДАХ БОЛ ЯАХ ВЭ?

- Та дараагийн худалдан авагчаа олж бидэнд мэдэгдснээр бид өмчлөлийг дараагийн хөрөнгө оруулагчид шилжүүлэх боломжтой.
- Эсхүл бид танд худалдан авагч олж өгөх боломжтой.
- Нийт нэгж эрх эзэмшигчдийн хурлын дийлэнх олонхийн (66.7%) саналаар тухайн торхыг тухайлсан бирж эсхүл зуучлагчдад хандан бүтнээр нь борлуулан хөрөнгө оруулалтаа татах боломжтой.



ВИСКИНИЙ ТОРХ ХУДАЛДАН АВАХАД БИД ТАНД ЯМАР АЖЛУУДЫГ ХИЙЖ ӨГЧ БАЙГАА ВЭ?

1. Хаанаас вискиний торх худалдах авахаа сонгох

- Шууд виски нэрэх үйлдвэрээс
- Гуравдагч этгээд, зуучлагчаар дамжуулах
- Хадгалалт, хадгалалтын зардлыг тооцоолох

3. Хөрөнгө оруулалтын хугацааг сонгох – Хамгийн багадаа 3 жил

- Нэрж дуусах эцсийн хугацаа хүртэл хадгалах
- Эцсийн хугацаанаас өмнө лонхонд савлах боломж

5. Хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ

- Нийт хүлээгдэж байгаа өгөөж
- Ирээдүйн үнэ цэнийн төсөөлөл
- Нэгж эрхийн тооцоолол
- Шимтгэл, хураамжийн дараах цэвэр ашиг

7. Хөрөнгө оруулалтыг гүйцэтгэх

- Танилцуулга бэлтгэх
- Торхоо худалдан авах
- Хөрөнгө оруулагчдад танилцуулах
- Худалдан авалтын төлбөрийг гүйцэтгэх
- Тайлагнал
- Тодорхой хугацааны хөрөнгө оруулалтаа татах нөхцөл байдал

2. Авах вискиний төрөл, брэндийг сонгох

- Зах зээлийн судалгаа
- Single malt/Single grain/Blended
- Шотланд | Япон | Тайвань | Франц

4. Зардлын дүн шинжилгээ

- Худалдан авах
- Хадгалах
- Савлах
- Тээвэрлэх
- Татвар ба бусад асуудал
- Ууршилтын хувь хэмжээ /жилд 2%-аас доош/

6. Бусад

- Худалдан авах үйл явц, гэрээ, гэрчилгээ
- Татвар, хураамж
- Зах зээл дээрх хөрвөх чадварыг тодорхойлох

8. Торхны өмчлөлийг баталгаажуулах

- Торх нь таны нэр дээр шилжсэн тухай гэрчилгээг авах
- Гэрчилгээг хадгалуулахаар Кастодиан банканд хүргүүлэх
- Хөрөнгө оруулагчдад өмчлөлийн баталгаа болгож Кастодиан банк болон Хөрөнгө оруулалтын менежментийн компаниас баталгаажуулах захидал ирснээр энэхүү хөрөнгө оруулалтын үйл явц дуусгавар болно.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЭРСДЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны хувийн хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын хүрээнд бид тус вискинд хөрөнгө оруулах шууд бус арга хэлбэрийг сонгосон байгааг та дараагийн хэсгээс харж болно.


Их Британи Умард Ирландын Вант улсын Вискиний зохицуулалтын дагуу бүх вискийг шиллэж гаргах бөгөөд ингэхдээ Гаалийн, Онцгой татвар, НӨАТ-ын татваруудыг ногдуулах тул шиллэж Монгол улс руу ирүүлэх тохиолдолд шил вискиний үнийг өсгөх шалтгаан болж байна. Иймд зөвхөн хөрөнгө оруулагч энэхүү нэмэлт төлбөрийн нөхцлийг зөвшөөрч байгаа тохиолдолд тээвэрлэн авчрах нөхцөлтэй болно.

ӨМЧЛӨЛ

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд вискиний торхонд хөрөнгө оруулахад тодорхой хязгаарлалт байгаа тул бид 2 шатлалт өмчлөлийн бүтэц бүхий хөрөнгө оруулалтын хэрэгслийг санал болгож байна

КАСТОДИАН

Тус вискиний торхыг өмчилж буй компанийн хувьцаагаар баталгаажсан хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг Голомт банкны кастодианд бүртгүүлэн өмчлөл болон нэгж эрхийг баталгаажуулах юм.



ДААТГАЛ

Вискиний торх нь тухайн агуулахдаа даатгагдсан бөгөөд таны хөрөнгө оруулсан нэгж эрхийн үнэд 5 жилийн даатгалын үйлчилгээний төлбөрийг шингээсэн бөгөөд 5 жилээс өмнө худалдан борлуулах тохиолдолд шинэ өмчлөгчөөс үлдэх жилүүдийн даатгалын төлбөрийг суутган авна.

БИДНИЙ ТУХАЙ

МАНАЙ БАГ



B. Gerelmaa
CEO
Policy, technology, business



A. Kherlenchimeg
COO
Finance, governance



A. Munkhзориг
CFO
Finance, governance



S. Peter
CTO
Fintech, cs, startups



L. Saruul
Operation manager
Mongolian International
University BA in Biotechnology



G. Nandinbileг
Business development manager
National University of Mongolia BA
in Accounting



N. Enzo
Software engineer
Stockholm University, BA in Computer
Science



M. Sonny
Software engineer
New York University, BA in Computer
Science



N. Buyandelger
Financial analyst
Asia University (TW), BA in Financial
Management

ЗӨВЛӨХ БАГ



G. Tuvshinbileг
Mongolian Banking and Finance



Isabel Pinto
Real estate agent at Compass



Hyukjae Jang
Software Engineer at Line Plus
Co.



Len Ball
Digital change management
Canadian Banking, startups



Sung Won Park
NY Lawyer, Finance



Charles François Latchoumane
Neuroscientist
Georgia Tech

АСУУЛТ & ХАРИУЛТ

Хэрвээ би өөрийн нэр дээрээ вискигээ шилжүүлж авах хүсэлтэй байвал яах вэ?

Торхноос вискийг шиллэж илгээхэд дээр дурдсан онцгой болон гаалийн татвар хураамжууд болон тээвэрлэлттэй холбоотой нэмэлт зардлуудыг та төлөхийг зөвшөөрвөл бид танд таны нэрийн вискийг явуулж болно. Гэхдээ та мөн вискийгээ нэрэгдэж дуусахыг хүлээх хэрэгтэй. Мөн шилэнд савлуулахад дараах нэмэлт зардлуудыг төлөх юм.

Шилтэй вискиний өртөг	Glen Moray	BenRiach
Вискиний үнэ	£ 18.84	£ 34.09
Шиллэх хөлс	£ 3.00	£ 3.00
Татвар	£ 19.84	£ 19.84
НӨАТ	£ 8.34	£ 11.39
Монгол руу хүргэлт	£ 8.00	£ 8.00
1 шил вискиний нийт өртөг	£ 58.02	£ 76.32
Виски шиллэх нэмэлт зардал	£ 39.17	£ 42.22

Миний торхтой виски яаж байгаа бол?

Хэрвээ та ИБУИВУ-д айлчлах бол бид танд таны торхтой вискийг хадгалж байгаа дестиллери компани дээр зочлох боломжтой.

Хэрэв миний торхтой вискинд муу юм тохиолдвол яах вэ?

Таны торх вискиг бид Шотландад мэргэжлийн даатгалын үйлчилгээнд хамруулсан ба сонгогдсон даатгалын компани, даатгалын гэрээний хуулбар зэргийг бид таны захиалгыг баталгаажуулсны дараа тухайлан мэдэгдэх болно.

Миний торхыг хаана хадгалах вэ?

Торх нь Шотландад зөвшөөрөлтэй, торхтой вискиний тусгай агуулахад хадгалагдана.

Би вискиний торхон дээрээ очиж болох уу?

Тиймээ, та очиж болно. Ингэхдээ бидэнд урьдчилан мэдэгдэх ба бид дестиллери компанид таныг очих талаар мэдэгдсэнээр та биечлэн очих боломжтой:

Энэ торх нь жинхэнэ гэдгийг би яаж мэдэх вэ?

Их Британи Умард Ирландын вант улсын Засгийн газрын маш хатуу зохицуулалтын доор бүх торхууд “Delivery order” гэсэн бүртгэл хөтөлдөг ба торх бүрт дахин давтагдашгүй бүртгэлийн дугааруудыг олгосон байдаг тул хуурамчаар хийх, бүртгэлийн дугааргүй борлуулах боломжгүй байдаг.

БИДЭНТЭЙ ХОЛБОГДОХ
976-7577-9444
invest@orda.mn